

ТАНИЛЦУУЛГА

*Согтууруулах ундааны эргэлтэд хяналт
тавих, архидан согтуурахтай тэмцэх
тухай хуулийн төсөл*

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөлд согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, үйлчлэх, хэрэглэх, архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг цогц байдлаар “зохистой хэрэглээг” бий болгох үндсэн зорилгыг удирдлага болгон тусгалаа. Хуулийн төсөл нь 7 бүлэг 45 зүйлтэй.

1.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд “согтууруулах ундаа” гэж хүнсний зориулалтын түүхий эдээр үйлдвэрлэсэн спирт, бүх төрлийн архи, 2-оос дээш хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан дарс, тэдгээрийн үндсэн дээр бэлтгэсэн ундаа, шар айраг, сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архийг, “согтууруулах ундааны эргэлт” гэж согтууруулах ундааг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түүгээр үйлчлэх, хэрэглэхийг тус тус ойлгохоор тодорхойллоо.

2.Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт согтууруулах ундааны үйлдвэрлэлтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицууллаа. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний үр дүнд үндэслэн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг тодорхой тусгаж, тусгай зөвшөөрөл олгох төсөл сонгон шалгаруулалт явуулах журмыг Засгийн газар батлахаар, тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, ашиглуулахыг хориглох, тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлага зэргийг тодорхойлсон.

Түүнчлэн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар олгохоор, экспортлох зорилгоор сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архийг чөлөөт бүсэд үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг чөлөөт бүсийн захирагч олгохоор тус тус тусгалаа.

Мөн энэхүү бүлэгт согтууруулах ундааны үйлдвэрлэлд тавигдах шаардлагуудыг шинээр тодорхойлохдоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хатуулгийг бүртгэж, эрх бүхий байгууллагад тогтмол мэдээлэх төхөөрөмжтэй байх, үйлдвэрлэх шаардлагатай бүтээгдэхүүний зохих доод хэмжээг тусгай зөвшөөрөлд тусгах, орц, найрлага, түүхий эд, этилийн спиртийн агууламж ижил, нэг төрлийн согтууруулах ундааг нэгээс дээш нэрээр үйлдвэрлэхийг хориглох заалтууд оруулав.

Согтууруулах ундааны шошго, савлагаанд тавигдах шаардлагыг тусгаж, гадаад улсад экспортлохоос бусад тохиолдолд худалдаанд гаргах согтууруулах ундааны савлагааны хэмжээг тогтоосон бөгөөд энэ нь согтууруулах ундааны зохистой хэрэглээг бий болгох зорилготой юм.

3.Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт согтууруулах ундаа импортлох, экспортлох, реэкспортлох үйл ажиллагааг зохицууллаа. Согтууруулах ундаа импортлох зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар, хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан журмын дагуу олгохоор тусгасан болно.

4.Хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицууллаа. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журмыг улсын хэмжээнд нэгдмэл байдлаар Засгийн газар баталдаг байхаар, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох нөхцөлүүдийг боловсронгуй болгож, үндэслэл бүрийг хуулийн төсөлд нарийвчлан тусгасан.

Энэхүү бүлэгт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгох хэмжээг нийгмийн зарим үзүүлэлтүүдийг харгалзан, урьдчилан тогтоосны үндсэн дээр согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг ашгийн төлөө, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдэд, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдэд олгохоор тусгалаа. Согтууруулах ундаагаар үйлчлэх этгээдэд олгох тусгай зөвшөөрлийг тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан 2 төрөлтэй байхаар тусгалаа.

Олон нийтийг хамарсан зарим үйл ажиллагааны үед согтууруулах ундаагаар үйлчлэх хэрэгцээ, шаардлага үүсдэгийг харгалзан түр хугацааны, нэг удаагийн шинжтэй согтууруулах ундаагаар үйлчлэх түр зөвшөөрөл олгож, хариуцлагатайгаар үйлчилдэг байхаар шийдвэрлэлээ.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох газар, зүйлийн талаарх зохицуулалтыг шинээр боловсруулж, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зааснаас гадна согтууруулах ундааг зайнаас /холбоо, мэдээллийн сүлжээ ашиглан/ болон өөртөө үйлчлэх автомат төхөөрөмж ашиглан, эсхүл гар дээрээс, эсхүл согтууруулах ундааг хаягаар хэрэглэгчид хүргэхийг хориглохоор тусгалаа. Мөн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох өдөрт Бүгд Найрамдах Улс тунхагласан өдөр, үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр, сонгуулийн санал авах өдрийн өмнөх, дараах өдөр гэх зэргийг нэмж “архигүй өдрийн” тоог нэмлээ.

Аймаг нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нар харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтоохоор заалаа.

Мөн согтууруулах ундааны хэрэглээ, түүний худалдаатай холбоотой үйл ажиллагааны талаарх дараах шинэлэг зохицуулалтыг хуулийн төслийн энэхүү бүлэгт тусгасан:

- Согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөл эзэмшигч нь үйлчлүүлэгчид зориулсан худалдан авсан согтууруулах ундааг хэрэглэх танхимтай байх;
- Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс худалдан авсан согтууруулах ундааг зөвхөн дээр дурдсан танхимд хэрэглэх;

- Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 35 хувиас дээш хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундааг үйлдвэрийн лонх, савалгаатай нь худалдаж үйлчлэхийг хориглох;
- Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээний танхимдаа халуун, хүйтэн зуушаар үйлчлэх болон ундны усаар үнэ төлбөргүй үйлчлэх;
- Согтууруулах ундаагаар үйлчлэх танхимд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох болон хэтрүүлэн хэрэглэсний улмаас үүсэх хор уршгийн талаар санамж, такси, нийтийн тээврийн үйлчилгээний талаарх мэдээллийг байршуулах;
- Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бусдад үйлчлэх үүрэг бүхий ажилтан нь согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтад хамрагдсан байх;
- Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан нь үйлчлүүлэгч хуульд заасан насанд хүрээгүй гэх үндэслэл байгаа тохиолдолд үйлчлэхийн өмнө хуулиар зөвшөөрөгдсөн насанд хүрсэн эсэхийг шалгах зорилгоор үйлчлүүлэгчийн бичиг баримтыг заавал шалгах;
- Хорин нэгэн насанд хүрээгүй, эсхүл согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн хүнд согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсний улмаас бусдад учруулсан гэм хорыг согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцах.

5.Хуулийн төслийн 6 дугаар бүлэгт архидан согтуурах, согтууруулах ундааны хэрэглээг нэмэгдүүлэх зорилго бүхий аливаа үйл ажиллагааг хориглох зохицуулалтуудыг тусгасан. Тухайлбал,

- Зар сурталчилгааны тухай хуулийн 14¹.4-т зааснаас бусад тохиолдолд спортын, соёл, урлагийн болон нийтийг хамарсан арга хэмжээ, нэвтрүүлгийн үеэр согтууруулах ундааны зар сурталчилгаа явуулах, байршуулах;
- Төрийн бэлгэ тэмдэг, түүхэн хүний нэр, зургийг, согтууруулах ундааны нэр, лого, барааны тэмдэг, зураг, сурталчилгаанд ашиглах;
- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд хямдрал, урамшуулал зарлах, хөнгөлөлттэй үнэ, нөхцөлөөр худалдах, үйлчлэх болон урамшуулал, хөнгөлөлтийг илэрхийлсэн утгатай зар сурталчилгаа ашиглах;
- Согтууруулах ундаагаар дээж, загвар хэлбэрээр үнэ төлбөргүй үйлчлэх, бусдыг дайлах, амтлагаа зохион байгуулах;
- Нэг тогтоосон үнээр хязгааргүй хэмжээгээр согтууруулах ундаагаар үйлчлэх;
- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч согтууруулах ундааг зээлээр худалдах, түүгээр зээлээр үйлчлэх;
- Согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээний талаар төрөл бүрийн сугалаа, хонжвор, аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа явуулах;
- Согтууруулах ундааны нэрээр хуулийн этгээдийг нэрлэх, эсхүл хуулийн этгээдийн нэрээр согтууруулах ундааг нэрлэх;
- Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэйгөөс бусад газарт эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах ундаа болон согтууруулах ундааны зураг, нэр, тэмдэг хэрэглэх зэргийг хориглохоор тусгав.

Түүнчлэн энэ бүлэгт архидаг согтуурахтай тэмцэх чиглэлээр согтууруулах ундааны зар сурталчилгаа, түүнд тавигдах хязгаарлалт, архидаг согтуурахын эсрэг сурталчилгаа, албадан эрүүлжүүлэх, эмчлэх үйл ажиллагаатай холбоотой дараах зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

- Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, архидаг согтуурсан этгээдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах, донтох өвчний хор уршигтай тэмцэх Засгийн газрын санг байгуулах бөгөөд уг сантай холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулахаар;
- Сангийн хөрөнгөөс Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд¹ заасан тусламж, үйлчилгээний зориулалтаар зарцуулж болохоор;
- Согтууруулах ундааг сурталчлахад хорин нэгэн насанд хүрээгүй хүн оролцуулах болон түүнд хэрэглэхийг зааж сургахыг хориглохоор;
- Согтууруулах ундааны зар сурталчилгааны үед согтууруулах ундааны хор хөнөөлийн талаарх сэрэмжлүүлгийг заавал байршуулахаар заалаа.

Энэ бүлэгт туссан архидаг согтуурах болон донтох өвчний хор уршигтай тэмцэх Засгийн газрын сангийн хөрөнгийг спиртээс бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх болон согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлдвэрлэсэн, нийлүүлсэн бүтээгдэхүүнээс литр тутамд 18-37 хүртэлх хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундаанд 200 төгрөг, 37, түүнээс дээш хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундаанд 300 төгрөгөөр тооцон, онцгой албан татварын хамт төлүүлж бүрдүүлэхээр хуулийн төслийг дагалдан гарах Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгав. Үүнд:

6.Хуулийн төслийн 7 дугаар бүлэгт согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, экспорт, реэкспорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам болон хяналт тавих эрх бүхий субъектүүдийг тодорхойлж, тэдгээрээс хэрэгжүүлэх чиг үүргийг тусгав.

Энэ бүлэгт экспортлохоос бусад Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн болон импортолсон архи, дарс онцгой албан татварын тэмдэгтэй байх бөгөөд онцгой албан татварын тэмдэггүй согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох, импортолсон согтууруулах ундааны онцгой албан татварын тэмдэг дээр тухайн бүтээгдэхүүнийг импортолсон этгээдийг танин баталгаажуулах боломжийг бүрдүүлсэн байхаар тусгалаа.

Дээрхээс гадна согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэл болон тэдгээртэй холбоотой шийдвэрийн талаархи мэдээллийг агуулсан мэдээллийн цахим санг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэхээр үүрэгжүүлээ.

7.Хуулийн төсөлтэй уялдуулан Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт

¹ Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 44 дугаарт нийтлэгдсэн.

оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг холбогдох хуулийн төслүүдийг боловсруулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР